



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 1/2023

Номгон

Баруун бүсийн аймгуудын хоол үйлдвэрлэл,
үйлчилгээний ажилчдын ур чадварын тэмцээн
зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, Ерөнхий боловсролын сургуулийн Хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.1, 10.6.1, Монгол улсын Их хурлын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолын 5/К, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдтай 2023 онд хамтран ажиллах гэрээний 29, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 2.2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Улаанбаатар хотноо 2023 оны 09 дүгээр сард зохион байгуулагдах "Чингис Хааны Цом 2023" олон улсын хоолны фестивалийн бэлтгэл ажлын хүрээнд Монгол үндэсний болон орон нутгийн онцлогтой хоол, ундааг сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэх, салбарын ажилтан, ажилчдын ур чадвар, чадамжийг дээшлүүлэх, туршлага солилцох зорилгоор Баруун бүсийн аймгуудын хоол үйлдвэрлэл үйлчилгээний ажилчдын "Ур чадварын уралдаан"-ыг 2023 оны 05 дугаар сарын 11 -14- ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, шаардагдах төсвийн тооцоог 2 дугаар хавсралтаар, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Арга хэмжээний зардал 10 000 000 /арван сая/, төгрөгийг 2023 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажил мэргэжлийн уралдаанд (Увс, Ховд, Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай) аймгуудын хоол үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлал, амралт сувиллын газрыг өргөн хүрээтэй оролцуулж, төрийн бус

642310559

байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллахыг ажлын хэсэг (Б.Батсуурь)-т даалгасугай.

ДАРГА



МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр
сарын 26 ны өдрийн 1126 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Батсуурь Засаг даргын орлогч

Гишүүд:

Т.Хишигбаатар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга

У.Балжинням Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

Ж.Алтанцэцэг Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Н.Шагдарсүрэн Стандарт хэмжил зүйн хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

Н.Энхжаргал Эрүүл мэндийн газрын дарга

Б.Пүрэвдагва Хөгжимт драмын театрын дарга

Б.Оюунбаатар Биеийн тамир, спортын газрын дарга

Д.Бат-Орших Баянхонгор Политехникийн коллежийн захирал

Ц.Уламбаяр Баянхонгор Эрчим хүч ЦТ ХХК-ний захирал

П.Цэрэнпагма Баянхонгор Политехникийн коллежийн багш,
Баянхонгор аймгийн хоол үйлдвэрлэгчдийн холбооны
тэргүүн

Р.Пүрэвсүрэн Аймгийн Түүх угсаатны зүй байгалийн түүхийн музейн
захирал

Б.Энхтүвшин Худалдаа аж үйлдвэрийн танхимын Баянхонгор аймаг
дахь салбарын захирал

Д.Содномсамдан Байгаль, орчин аялал жуулчлалын газрын ахлах
мэргэжилтэн

Ц.Азжаргал Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

С.Сайнхүү Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнс, нийтийн хоол,
худалдааны асуудал хариуцсан мэргэжилтэн

М.Балдангомбо Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний худалдааны улсын
Байцаагч

2.

Ч.Жавзандулам Хоол, үйлдвэрлэл үйлчилгээний улсын байцаагч

Д.Баасанцэрэн Эрүүл мэндийн газрын Халдвар, хамгааллын хяналтын улсын байцаагч

А.Өлзийсайхан Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Б.Биндэръяа Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хүнс, худалдаа, үйлдвэр үйлчилгээний бодлого хариуцсан мэргэжилтэн

_____оОо_____

Аймгийн Засаг даргын хялбар оны 2023.04.04 дүгээр сарын 25 өдрийн 44/2023 н. дугаар 1 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралт



БАРУУН БҮСИЙН АЙМГУУДЫН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
 АЖИЛЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ "БҮСИЙН АВАРГА ТОГООЧ, ЗӨӨГЧ
 ШАЛГАРУУЛАХ УР ЧАДВАРЫН УРАЛДААН-2023"
 АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	нэг бүрийн үнэ	Мөнгөн дүн
1	Анонс	1	400000	400000
2	LED дэлгэц, хөгжим түрээс	2	500000	1000000
3	Мандат	200	5000	1000000
3	Медаль	150	15000	2250000
4	Өргөмжлөл	100	15000	1500000
5	Аймгуудад өрөх дурсгалын зүйл /б аймаг, холбоо/	12	100000	1200000
6	Хөөсөн батламж /хаяг/	6	10000	60000
7	Цом	6	150000	900000
9	Шүүгчийн хөлс	10	100000	1000000
10	Үдийн цайны материал	200	2450	490000
				Нийт
				10000000

Аймгийн Засаг даргын 2022 оны 6 дүгээр
сарын 25 ны өдрийн 16 дугаар захирамжийн
3 дугаар хэвсгэлт.



БАРУУН БҮСИЙН АЙМГУУДЫН ХООЛҮЙЛДВЭРЛЭЛ
ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН АЖИЛ МЭРГЭЖЛИЙН УР
ЧАДВАРЫН УРАЛДААН, СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх ажил арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Тайлбар
1	2	3	4	5
1	Захирамж төлөвлөн гаргах	04/10-15	Б. Биндэръяа	
2	Баруун бүсийн аймгуудад албан бичиг хүргүүлэх	4/10-4/20	Б. Биндэръяа	
3	Сумдад албан бичиг хүргүүлэх	4/10-4/20	У.Балжинням Н.Энхжаргал Ж.Алтанцэцэг	
4	Бүсийн арга хэмжээний удирдамж боловсруулан батлуулах	4/10	Б. Биндэръяа П.Цэрэнпагма	Монголын Тогооч нарын нэгдсэн холбоо
5	Арга хэмжээний урилга, хөтөлбөр гаргах	5/9-11	Б. Биндэръяа П.Цэрэнпагма	
6	Анонс, мандатын эх бэлтгэн хэвлүүлэх	5/9-11	Б. Биндэръяа С.Сайнхүү П.Цэрэнпагма	
7	Хэвлэл мэдээллийн асуудал, нэвтрүүлэг, зураг авалт, шууд дамжуулалт	5/12-14	Т.Хишигбаатар Н.Шагдарсүрэн	
8	Лед дэлгэц байрлуулах	5/11	Т.Хишигбаатар Д.Бат-Орших	
9	Ур чадварын уралдаан болон спортын арга хэмжээний байр бэлтгэх	5/11	Б.Оюунбаатар Политехникийн коллеж, ХХААГ Аймгийн хоол үйлдвэрлэлийн холбоо	Сандал, ширээ, ширээний бүтээлэг, хогийн сав, уут, скоч, техник хангамж гэх мэт
10	Увс, Ховд, Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын оролцогчдын мэдүүлэг авах	5/1-10	Б. Биндэръяа П.Цэрэнпагма	6 аймаг
11	Сумдын оролцогчдын мэдүүлэг авах			20 сумын оролцогч
12	Оролцогчдыг байрлуулах, байраар хангах	5/11	Т.Хишигбаатар Ж.Алтанцэцэг	Бүх ажлын хэсэг

1	2	3	4	5
13	Шүүгч нарыг байрлуулах	5/11	Т.Хишигбаатар П.Цэрэнпагма	Улаанбаатар хотоос ирэх 10-15 хүн
14	Оролцогчдыг бүртгэх	5/12-14	С.Сайнхүү М.Балдангомбо Ч.Жавзандулам	
15	Тогоочдын ур чадварын уралдааны хураамж авах	5/10-11	П.Цэрэнпагма	Аймгийн Хоол үйлдвэрлэгчдийн холбоо
16	Оролцогчдын хоолны асуудлыг шийдэх	5/11-14	Ж.Алтанцэцэг Ч.Жавзандулам	Аймгийн Хоол үйлдвэрлэгчдийн холбоо
17	Шүүгч нарын хоолны асуудал	5/11-14	Т.Хишигбаатар П.Цэрэнпагма Ч.Жавзандулам	
18	Ур чадварын уралдааны техникийн зөвлөгөөн	5/11	Монголын Тогооч нарын нэгдсэн холбоо, Аймгийн Хоол үйлдвэрлэгчдийн холбоо	Хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа.....
19	Гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулах	5/13	Б.Оюунбаатар - БТСГ Аймгийн хоол үйлдвэрлэгчдийн холбоо	
20	Урлагийн арга хэмжээ үзүүлэх, арга хэмжээг хөтлөх	5/12-13	Хөгжимт драмын театр Политехникийн коллеж	
21	Бэлэг дурсгалын зүйл бэлтгэх	5/01-5/10	ХБТХОХ, Аймгийн Хоол үйлдвэрлэгчдийн холбоо	
22	Шагнал бэлтгэх	5/11	Б.Биндэрьяа П.Цэрэнпагма С.Сайнхүү	
23	Оройн зоог, шагнал гардуулах үйл ажиллагаа	5/13	Б.Биндэрьяа П.Цэрэнпагма С.Сайнхүү А.Өлзийхишиг	
24	Музей үзүүлэх	5/13	Р.Пүрэвсүрэн	
25	Ивээн тэтгэгч иргэн, ААН байгууллага олох	4/10-5/10	Б.Батсуурь Т.Хишигбаатар Б.Энхтүвшин	
26	Цахилгаан эрчим хүчний байдлыг хангах, ил задгай утас далдалж, уртасгагч байрлуулах, хураах	5/11	Эрчим хүч	Далдлагч, утас бэлтгэж өгөх